ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр Дугаар 604 Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 70 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөвсгөл аймгийн өмчөөс шилжүүлсэн 13,000,000.00 (арван гурван сая) төгрөгийн балансын үнэ, 260,000.00 (хоёр зуун жаран мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж, бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ё.Пүрэвсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хүлээн авсан үл хөдлөх хөрөнгөд хамаарах газрын эзэмших эрх (биет бус хөрөнгө)-ийг Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын нэр дээр шилжүүлэн авч, баталгаажуулах;

2.2.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132006987

\Huraldaanii material\2021 on\2021.12.14 22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн
604 дугаар тогтоолын хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАРТ ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
Барилга байгууламж							
1	Цагаан-Уул сумын гал унтраах 73-р ангийн байр	1990	ш	1	13,000,000.00	260,000.00	12,740,000.00
Нийт дүн					**13,000,000.00**	**260,000.00**	**12,740,000.00**
					(арван гурван сая)	(хоёр зуун жаран мянга)	(арван хоёр сая долоон зуун дөчин мянга)